

# **ХУУЧИН МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ ХУДАЛДАХ, ХАДГАЛАХ ЖУРАМ**

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү журмын зорилго нь Монголбанкны нөөцөд байгаа Монгол Улсын 1992 оноос өмнөх, гүйлгээнээс хасагдсан мөнгөн тэмдэгт болох зоосон болон цаасан дэвсгэрт, тэдгээрийн цаасан загвар, дурсгалын зориулалтаар үйлдвэрлэсэн зоосон мөнгөн тэмдэгт (цаашид “хуучин мөнгөн тэмдэгт” гэх)-ийг иргэн, хуулийн этгээд (цаашид “сонирхогч этгээд” гэх)-д худалдах, хадгалахтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журмыг Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (цаашид МБСГ гэх), Тамгын газар (цаашид ТГ гэх) болон Төлбөр тооцоо, бүртгэлийн газар (цаашид ТТБГ гэх) тэдгээрийн захирал, ажил хариуцсан эдийн засагч, нягтлан бодогч, нярав нар үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

## **ХОЁР. ХУУЧИН МӨНГӨН ТЭМДЭГТИЙН НӨӨЦИЙГ АНГИЛАХ**

2.1 Хуучин мөнгөн тэмдэгтийн нөөцийг ангилахдаа дараахь үндсэн хоёр хэсэгт хуваана:

2.1.1 Худалдахыг хориглосон хуучин мөнгөн тэмдэгт: Үүнд тухайн хуучин мөнгөн тэмдэгтийн нөөцийн хэмжээ нь ширхэгээр 5000/таван мянга/ ба түүнээс бага тоотой байгаа мөнгөн тэмдэгт хамаарна.

2.1.2 Хязгаарлагдмал хүрээнд дуудлага худалдаагаар худалдах хуучин мөнгөн тэмдэгт: Үүнд тухайн хуучин мөнгөн тэмдэгтийн нөөцийн хэмжээ нь ширхэгээр 5001/таван мянга нэг/-ээс дээш тоотой байгаа хуучин мөнгөн тэмдэгт хамаарна. Дуудлага худалдаагаар нэг жилд худалдах хуучин мөнгөн тэмдэгтийн тоо хэмжээг МБСГ-аас Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хуралд танилцуулж зөвшөөрөл авна.

## **ГУРАВ. ХУУЧИН МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ҮНЭ ТОГТООХ**

3.1 Энэ журмын 2.1.2-т заасан хуучин мөнгөн тэмдэгтийг худалдах үнийн саналыг МБСГ, ТГ-аас хуучин мөнгөн тэмдэгтийн зах зээлийн үнийг үндэслэсэн боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчид тухай бүр танилцуулна. Хуучин мөнгөн тэмдэгтийг худалдах үнийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.

## **ДӨРӨВ: ХУУЧИН МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ ХУДАЛДАХ**

4.1 Энэ журмын 2.1.2-т заасан хуучин мөнгөн тэмдэгтийг зөвхөн дуудлага худалдаагаар худалдана.

4.2 Дуудлага худалдааг ТГ-аас зохион байгуулах бөгөөд хамгийн өндөр үнэ хэлснээс эхэлж дуудах журмаар жилд нэгээс дээшгүй удаа явуулна.

4.3 Дуудлага худалдааны зарыг дуудлага худалдаа явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон Монголбанкны цахим хуудсаар олон нийтэд мэдээлнэ.

4.4 Энэ журмын 2.1.2-т заасан мөнгөн тэмдэгтийг худалдах тоо хэмжээг МБСГ-аас ширхэгээр тооцож, саналаа жил бүр Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулна. Хуучин мөнгөн тэмдэгтийн худалдах хэмжээг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлана.

4.5 Хуучин мөнгөн тэмдэгтийн эх загварыг худалдахыг хориглоно.

4.6 Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалыг үндэслэн Тамгын газрын Үйлчилгээ, аж ахуйн хэлтэс /хариуцсан нярав/ хуучин мөнгөн тэмдэгтийг худалдах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

4.7. Тамгын газрын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн нярав нь хариуцсан нягтлан бодогчийн хянаж зөвшөөрсөн захиалагчийн хүсэлт, өргөдлийн дагуу сонирхогч этгээдээс төлбөрийг хүлээн авч, тушаасан баримтыг үндэслэн хуучин мөнгөн тэмдэгтийг олгоно. Сонирхогч этгээдийн гаргасан баримт, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалыг үндэслэн Төлбөр тооцоо, бүртгэлийн газрын нягтлан бодогч гүйлгээ хийх ба энэхүү гүйлгээний мөнгө тушаасан баримтыг үндэслэн нярав олгоно.

4.8. Худалдан борлуулсан мөнгөн тэмдэгтийн тайланг хавсралтын дагуу улирал тутамд гаргаж, Тамгын газрын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн захиралд танилцуулна.

4.9 Нэн ховордсон хуучин мөнгөн тэмдэгтийг Монголбанкны Эрдэнэсийн сангийн үзмэрийг баяжуулах зорилгоор харилцан тохиролцсны үндсэн дээр бусад банк, аж ахуйн нэгж, иргэдээс худалдан авч болно.

## **ТАВ.ХУУЧИН МӨНГӨН ТЭМДЭГТИЙГ ХАДГАЛАХ**

5.1 Хариуцсан нярав худалдах хуучин мөнгөн тэмдэгтийг зориулалтын тусгай сейф, хамгаалалтын сав, хайрцагт хадгална.

5.2 Хуучин мөнгөн тэмдэгтийг цаасан дэвсгэрт, зоос тус бүрээр тусгаарлаж хадгална.

### **ЗУРГАА. ХЯНАЛТ ХАРИУЦЛАГА**

Энэ журмыг зөрчсөн этгээдэд тухайн зөрчлийн шинж байдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Монголбанкны Хөдөлмөрийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.